

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2020 оны VI сарын 10-ны өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2020 оны 06 дугаар сарын II долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 8 нэрийн барааны үнэ (25.0%) **тогтвортой**, 10 нэрийн барааны үнэ (31.2%) **буурсан**, 14 нэрийн барааны үнэ (43.8%) **өссөн** байна. Үүнд:

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> “Алтан Тариа” задгай гурил I “Алтан Тариа” савласан гурил I “Алтан Тариа” савласан гурил II Цагаа будаа, “Заантай” Шар будаа Цөцгийн тос, “Сүү” ХК Ямааны мах, ястай Алим, фүжи 	<ul style="list-style-type: none"> “Алтан Тариа” задгай гурил дээд “Алтан Тариа” савласан гурил дээдийн дээд “Алтан Тариа” савласан гурил дээд “Сүү” ХК савласан 0.5 л сүү Сүү, задгай Талх, “Атар” Ургамлын тос, “Янта” Ногоон цай, “Сtimo” Элсэн чихэр, “Заантай” Өндөг, ОХУ 	<ul style="list-style-type: none"> “Сүү” ХК савласан 1 л сүү “Сүү” ХК тараг, Цөцгийтэй Талх, “Зууван чех” Талх, “хөх тарианы хар” Хонины мах, ястай Хонины мах, цул Үхрийн мах, ястай Үхрийн мах, цул Адууны мах, ястай Төмс, монгол Лууван, монгол Байцаа, монгол Хүрэн манжин, монгол Сонгино, хятад

Махны дундаж үнэ

2020 оны 06 дугаар сарын II долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 10393 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 12640 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 260 төгрөгөөр (2.1%), үхрийн цул махны үнэ 168 төгрөгөөр (1.1%) тус тус өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 10800 төгрөг, Харин “Саруул” худалдааны төвд хамгийн өндөр үнэтэй буюу 15500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн нэг килограмм махны дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах


	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 665	11 735	11 940	12 640*						

Хонины ястай мах

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 125	10 393*						

* 2-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины нэг килограмм махны дундаж үнэ, төгрөг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 164 төгрөгөөр (1.6%), хонины цул махны үнэ 106 төгрөгөөр (1.0%) тус тус өссөн байв. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины ястай мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 8500 төгрөгөөр, харин “Саруул” худалдааны төвд хамгийн өндөр үнэтэй буюу 14500 төгрөгөөр худалдаалж байна.


Гурилын үнэ

2020 оны 06 дугаар сарын II долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1350-1500 төгрөг, 1-р зэргийнх 1100-1400 төгрөг, 2-р зэргийнх 900-1100 төгрөг байна.


Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1300-1500 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захуудад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1300 төгрөг, 1-р зэргийн гурил 1100 төгрөгөөр тус тус зарагдаж байна.



Зураг 3. Нэг килограмм будааны үнэ, төгрөг




Зураг 4. Нэг килограмм савласан гурилын үнэ, төгрөг



“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1199-1330 төгрөгийн үнэтэй байна. “Номин” супермаркет “Атар” талхыг хамгийн хямд буюу 1199 төгрөгөөр, харин “М-Март” супермаркет хамгийн өндөр үнээр буюу 1330 төгрөгөөр худалдаалж байна.

Хүнсний ногооны үнэ

Зураг 5. Нэг килограмм хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



2020 оны 06 дугаар сарын II долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 5.9 хувиар өсч 1047 төгрөгөөр, монгол лууван 5.0 хувиар өсч 2034 төгрөгөөр, монгол байцаа 6.5 хувиар өсч 2647 төгрөгөөр, монгол хүрэн манжин 6.1 хувиар өсч 3182 төгрөгөөр, сонгино 1.8 хувиар өсч 1684 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2020.VI.10
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2020 оны III, IV, V, VI сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2014-2020 оны VI сарын 10
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2020.VI.10
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2020 оны III, IV, V, VI сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2019-2020 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2020.VI.10